



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“ХЭЛЭЛЦСЭН нь: “Эрдэнэт Медикал” эмнэлгийн талаар авах арга хэмжээний тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр 28-ны өдрийн “Хойд бүсийн хөгжлийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоолын 1.3.3 дахь заалтаар “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын харьяа “Эрдэнэт медикал эмнэлэг” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төв болгон хөгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн яамны харьяанд шилжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэхийг Эрүүл мэндийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын харьяа “Эрдэнэт медикал эмнэлэг” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг эргэлтийн хөрөнгө, эргэлтийн бус хөрөнгө болон авлага, санхүүгийн тайланд бүртгэлтэй өр төлбөр, орон тооны хамт цогцолбороор нь Эрүүл мэндийн яамны харьяанд шилжүүлэх асуудлыг дэмжиж Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэв” гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



132320222

16-r huraldaan.docx